

## Хөлөг онгоцны галын ослын сургамжууд

2022 оны 04-р сар



2020 оны долоодугаар сарын 12-ны өдөр Калифорни мужийн Сан Диего хотын боомтод зогсож байсан, АНУ-ын Тэнгисийн цэргийн USS Бонхомме Ричард хэмээх хөлөг онгоцон дээр гал гарчээ. Таван өдрийн турш үргэлжилсэн тус гал хөлөг онгоцны 11-15 тавцанд тархсан ба галын температурын хэм 760 °C-ээс давсан байна. Ослоор 3 тэрбум долларын санхүүгийн хохирол учирсан бөгөөд хөлөг онгоцыг ашиглалтаас гаргажээ.

АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчин тус галаас өмнөх 12 жилийн хугацаанд хөлөг онгоцонд гарсан нийт 15 галын осолд судалгаа хийжээ. Судалгаагаар осол олон давтагдахад буюу гал үүсэх болон тархахад нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоожээ. Усан цэргийн хөлөг онгоцон дээр гал гарахад нөлөөлсөн тэдгээр хүчин зүйлсийн зарим нь үйлдвэрлэлийн орчинд гал үүсэх, ноцтой түвшинд тархахад нөлөөлөх боломжтой байсан.

Эх сурвалж "Major Fires Review Executive Summary, Commander, U. S. Fleet Forces Command and Commander, US Pacific Fleet, July 15, 2021 (Release October 19, 2021). <https://www.documentcloud.org/documents/21089015-for-release-major-fires-review-19-oct-21>

### Та мэдэх үү?

АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчний судалгаагаар илрүүлсэн ослын зарим хүчин зүйлээс үйлдвэрлэлийн орчинд хамаарахыг нь дурьдвал:

- Онгоцонд зөвшөөрөгдөөгүй материал тээвэрлэсэн.
- Шатамхай болон аюултай материалтай харьцах, хадгалах горим зөрчигдсөн.
- Зохиж журмууд мөрдөгдөөгүй, үзлэг шалгалт хангалтгүй.
- Хэт их хэмжээний шатамхай болон аюултай материалыг галын эрсдлийг анхааруулах тэмдэглэгээгүй зөөврийн савнуудад хадгалсан.
- Өндөр хэмийн ажилтай холбоотой нарийн судалгаа, зөвшөөрөл, хяналт байхгүй, галаас хамгаалах эсвэл гал гарсан үед мөрдөх аврах төлөвлөгөө байгаагүй.
- Ажилчид гал илрүүлэх болон унтраах систем, аваарын холбооны төхөөрөмжүүдийг ашиглах үр чадвар бүрэн эзэмшээгүй.

### Та юу хийж болох вэ?

- Хэрэв танай үйлдвэрт шатамхай болон бусад аюултай материалыг зөөврийн саванд хадгалдаг бол тус савыг ямагт тухайн материалыг хадгалахтай холбоотой дүрэм, стандартад нийцсэн, зориулалтын хэсэгт хадгал.
- Ашиглагдаагүй үлдсэн бөгөөд үйлдвэрлэлийн талбайд дахин хэрэглэх шаардлагагүй материалыг зориулалтын хадгалах хэсэг рүү нэн даруй буцаа.
- Үйлдвэрийн өндөр хэмийн ажил болон бусад зөвшөөрөл шаарддаг ажлын журмуудыг заавал мөрд.
- Аврах ажиллагааны туршилтад оролцох, туршилтын үеэр ямар нэгэн асуудал ажигласан бол мэдээлэх буюу аврах ажиллагааны журмыг сайжруулахад туслах хэрэгтэй.
- Танай үйлдвэрт ойрын хугацаанд аврах ажиллагааны туршилт хийгдээгүй бол хийх санал дэвшүүл.
- Эх сурвалжид өгөгдсөн, АНУ-ын Тэнгисийн цэргийн тайлангуудыг уншиж, танай үйлдвэрт хамаарах өөр сургамжууд байгаа эсэхийг нягтал.
- Өндөр хэмийн ажлын тухай "Beacon"-ы өмнөх дугааруудаас дахин унш. (6/2018, 5/2020, 8/2020, 8/2021, 3/2022, [www.aiche.org](http://www.aiche.org) - "Beacon").

**Ослын мэдээнээс үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой сургамжуудыг хайдаг бай!**